

БАТЛАВ.



КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ҮЕД ШААРДЛАГАТАЙ ХУВИЙН ХАМГААЛАХ ХЭРЭГСЭЛ НИЙЛҮҮЛЭХ ГЭРЭЭ

Дугаар № 408

Улаанбаатар хот

Нэг талаас Эрүүл мэндийн яам (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас МӨНХИЙН ТУН ХХК (цаашид "нийлүүлэгч" гэх) дараах зүйлийг харилцан охиролцож 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

Хувийн хамгаалах хэрэгсэл "нэг удаагийн халад" худалдан авах гэрээг (цаашид "бараа" гэх) 10,503,628,500 (арван тэрбум таван зуун гурвансая зургаан зуун хорин найман мянга таван зуу) төгрөгөөр (цаашид "гэрээний үнэ" гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

Хүснэгт 1. Нийлүүлэх бараа

Барааны нэр, төрөл	Багцийн дугаар	Үйлдвэрлэгч, Улс	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгж үнэ /НӨАТ орсон/	Нийт үнэ
Нэг удаагийн халад	Багц-5	Мөнхийн тун ХХК, Монгол улс	Ш	1,235,721	8,500₮	10,503,628,500₮
Нийт дүн						10,503,628,500₮

Захиалагч нь барааны нийлүүлэлтийн 10,503,628,500 (арван тэрбум таван зуун гурвансая зургаан зуун хорин найман мянга таван зуу) төгрөгийг улсын төсвийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

2. Нийлүүлэгч нь 1 нэр төрлийн барааг 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

3. Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:

- Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- Бусад шаардлагатай баримт бичиг¹;
- Тендер ба үнийн хуваарь;
- Гэрээний тусгай нөхцөл;
- Гэрээний ерөнхий нөхцөл;
- Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
- Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

4. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.

5. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.

6. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

Хүснэгт 2. Санхүүжилтийн хуваарь

Д/Д	Барааны нэр, төрөл	Багцийн дугаар	Урьдчилгаа /төгрөг/	Гүйцэтгэл /төгрөг/
1	Нэг удаагийн халад	Багц-5	5,251,814,250₮	5,251,814,250₮
	Нийт дүн		10,503,628,500₮	

ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

¹ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Энэ гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

- (а) “Гэрээ” гэж захиалагч, нийлүүлэгчийн хооронд тохиролцсон бараа нийлүүлэх гэрээг хэлнэ. Гэрээ нь талуудын гарын үсэг зурсан гэрээний маягт, түүнийг дагалдах хавсралт, бусад баримт бичгээс бүрдэнэ.
- (б) “Гэрээний үнэ” гэж гэрээний дагуу гэрээний үүргээ бүрэн биелүүлж хангалттай гүйцэтгэсний дагуу нийлүүлэгчид төлөх үнийг хэлнэ.
- (в) “Хоног” гэж хуанлийн хоногийг хэлнэ.
- (г) “Хүчинтэй болох хугацаа” Гэрээ хүчин төгөлдөр болох өдөр.
- (д) “Ашиглагч” Барааг хэрэглэх ГТН-д заагдсан эцсийн хэрэглэгчийг хэлнэ.
- (е) “ГЕН” Гэрээний Ерөнхий Нөхцөл.
- (ж) “Бараа” Гэрээний дагуу Захиалагчид нийлүүлэх бүх эм, эмнэлгийн хэрэгсэлийг хэлнэ.
- (з) “Захиалагч” гэж барааг худалдан авч буй гэрээний тусгай нөхцөлд нэрлэсэн байгууллагыг хэлнэ.
- (и) “Бүртгэлийн гэрчилгээ” хуулийн дагуу Монгол улсад бүртгэгдсэн гэрээгээр нийлүүлэх барааны гэрчилгээ.
- (к) “ГТН” Гэрээний Тусгай Нөхцөл.
- (л) “Үйлчилгээ” гэж тээвэрлэлт, даатгал болон бусад дагалдах үйлчилгээ, техникийн туслалцаа, сургалт зэрэг гэрээний дагуу нийлүүлэгчийн хариуцах үйлчилгээг хэлнэ.
- (м) “Байршил” ГТН-д заасан барааг хүргэх байршил.
- (н) “Нийлүүлэгч” ГТН-д заагдсан бараа болон үйлчилгээг гүйцэтгэх этгээдийг хэлнэ.

- 2.1 Энэ ерөнхий нөхцөлүүд нь гэрээний бусад хэсгийн заалтаас давуу үйлчлэхгүй.
- 3.1 Гэрээний дагуу нийлүүлэх бараа нь аль ч улсаас гарал үүсэлтэй байж болно

ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Тодорхойлолт (ГЕН-ийн Зүйл 1)	
ГЕН 1.1 (и)	Захиалагч нь: Эрүүл мэндийн яам
ГЕН 1.1 (о)	Нийлүүлэгч нь: Мөнхийн тун ХХК
ГЕН 1.1 (н)	Байршил: <i>Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, Шархад, Да хүрээ гудамж, 29-1 тоот.</i>
ГЕН 1.1 (е)	Ашиглагч байгууллага: ХӨСҮТ, аймаг, нийслэлийн ЭМГ, төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг тусгай мэргэжлийн төв, бусад байгууллага
2. Үйлчлэх хүрээ (ГЕН-ийн Зүйл 2)	
ГЕН 2	ГЕН-ийн 2-т хамаарах тусгай нөхцөл байхгүй
3. Барааны гарал үүслийн улс (ГЕН-ийн Зүйл 3)	
ГЕН 3	ГЕН-ийн 3-т хамаарах тусгай нөхцөл байхгүй
4. Стандарт (ГЕН-ийн Зүйл 4)	
ГЕН 4	Багц-5. Нэг удаагийн халад: Эмнэлгийн зориулалттай, нэг удаагийн, шингэн нэвтрэхгүй нэхээсгүй материалаар хийгдсэн, урт нь шилбэний дундаас доош байх, урт ханцуйтай, ханцуй баригчтай, бүстэй, урдуураа битүү. Тухайн улсын стандарт эсвэл Монгол улсын MNS6623-3:2016 стандартын шаардлага хангасан, тохирлын баталгаатай байна.
5. Гэрээний баримт бичгийг хэрэглэх (ГЕН-ийн Зүйл 5)	
ГЕН 5	ГЕН-ийн 5-т хамаарах тусгай нөхцөл байхгүй
6. Барааны бүртгэлийн гэрчилгээ (ГЕН-ийн Зүйл 6)	
ГЕН 6.1	Багц-5. Нэг удаагийн халад. Тохирлын гэрчилгээний дугаар: УБД0001773 Монгол улсын стандарт дугаар: MNS6623-3:2016
7. Оюуны өмчийн эрх (ГЕН-ийн Зүйл 7)	
ГЕН 7	ГЕН-ийн 7-д хамаарах тусгай нөхцөл байхгүй
8. Гүйцэтгэлийн баталгаа (ГЕН-ийн Зүйл 8)	
ГЕН 8.1	Гэрээний үнийн дүнгийн 5% -аар гүйцэтгэлийн баталгаа ирүүлнэ.
ГЕН 8.4	Энэ баталгаа нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш 28 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
9. Шалгах болон турших (ГЕН-ийн Зүйл 9)	
ГЕН 9.1	ХӨСҮТ-ийн холбогдох мэргэжилтнүүд шалгаж, туршина.
10. Баглаа боодол (ГЕН-ийн Зүйл 10)	
ГЕН 10.2	Тендерийн баримт бичгийн техникийн тодорхойлолтод заасан стандарт болон бусад шаардлагууд
11. Барааны нийлүүлэлт болон баримт бичгийн бүрдүүлэлт	

19. Мэдэгдэл (ГЕН-ийн Зүйл 29)

ГЕН 29.1

Эрүүл мэндийн яам, Засгийн газрын 8 дугаар байр,
Улаанбаатар-48, Олимпын гудамж-2

Захиалагчийн хаяг: Баянзүрх дүүрэг, 8-р хороо, Да хүрээ гудамж,
29-1 тоот, Мөнхийн тун ХХК-ийн байр.

0. Татвар, хураамж (ГЕН-ийн Зүйл 30)

ГЕН 30

"ГЕН-ийн 30-д хамаарах тусгай нөхцөл байхгүй" гэж бичих

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

двэрлэл, технологийн газрын

..... Н.Гэрэлт-Од

асаг, санхүү, хөрөнгө оруулалтын газрын

..... Д.Нарантуяа

эндийн яамны Эм, эмнэлгийн

, үйлдвэрлэлийн хэлтсийн дарга

..... Г.Цэцэнсанаа

эндийн яамны Эдийн засаг,

ийн хэлтсийн дарга

..... Т.Хонгорзул

эндийн яамны хуулийн хэлтсийн

ТЭН

..... Д.Мөнхцэцэг

эндийн яамны нярав

..... П.Энхболор

Улаанбаатар хот Сүхбаатар

Олимпын гудамж 2, Засгийн газрын VI

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Эм зүйч

..... Д.Өлзийжаргал

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 8-р хороо, Да хүрээ гудамж 29-1 тоот.

Утас: 77775653, 88245653, 86080521, 80085653

Харилцах банк: Капитрон банк

Дансны дугаар: 3053001197

